



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 7 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар  
хот

Хуваарь шинэчлэн батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинээр батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын хуралдаанд түр эзгүй байгаа Засгийн газрын гишүүний хариуцсан асуудлыг хэлэлцүүлэх хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Засгийн газрын хуралдаанд түр эзгүй байгаа гишүүний хариуцсан асуудлыг хуваарийн дагуу хэлэлцүүлэх Засгийн газрын гишүүн эзгүй тохиолдолд тухайн асуудлыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга танилцуулж байхаар тогтоосугай.

3. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Улсын Их Хурлын Байнгын хороодын хуралдаанд асуудал хэлэлцүүлэх гишүүн түр эзгүй тохиолдолд асуудлыг энэ тогтоолын хавсралтаар баталсан хуваарийн дагуу танилцуулж байхаар тогтоосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хуваарь шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 383 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

Ж.МӨНХБАТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНД ТҮР ЭЗГҮЙ БАЙГАА ЗАСГИЙН ГАЗРЫН  
ГИШҮҮНИЙ ХАРИУЦСАН АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

1.	Монгол Улсын Ерөнхий сайдын түр эзгүйд	Монгол Улсын Шадар сайд
2.	Монгол Улсын Шадар сайдын түр эзгүйд	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
3.	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын түр эзгүйд	Монгол Улсын Шадар сайд
4.	Батлан хамгаалахын сайдын түр эзгүйд	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
5.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын түр эзгүйд	Гадаад харилцааны сайд
6.	Гадаад харилцааны сайдын түр эзгүйд	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
7.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын түр эзгүйд	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
8.	Сангийн сайдын түр эзгүйд	Хууль зүй, дотоод хэргийн сайд
9.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын түр эзгүйд	Сангийн сайд
10.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын түр эзгүйд	Эрүүл мэндийн сайд
11.	Эрүүл мэндийн сайдын түр эзгүйд	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
12.	Барилга, хот байгуулалтын сайдын түр эзгүйд	Зам, тээврийн хөгжлийн сайд
13.	Зам, тээврийн хөгжлийн сайдын түр эзгүйд	Барилга, хот байгуулалтын сайд
14.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын түр эзгүйд	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
15.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын түр эзгүйд	Эрчим хүчний сайд
16.	Эрчим хүчний сайдын түр эзгүйд	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд